



**ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 5/54

Чингис хот

Н.Золбоог түр орлон гүйцэтгэгчээр  
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4. 24 дүгээр зүйлийн 24.1, 2011 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаачийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ын 3.2, 3.2.6, 4.1, 4.9, 5.2, 2018 оны 264 дүгээр тогтоол "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай"-ын 9 дүгээр хавсралтаар батлагдсан Төрийн захигааны албан тушаалын цалингийн сүлжээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн ам зүйн нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн бодлого хариуцсан мэргэжилтэн Г.Уянга нь жирэмсний болон амаржсаны амралтаа авах чөлөө авсан тул Нарангэрэл овогтой Золбоог тус албан тушаалд 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс Г.Уянгыг ажилдаа эргэн томилогдох хүртэлх хугацаагаар албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Г.Лхагвахатан -Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: Ж.Цэнджав -Нийгмийн бодлогын хэлтсийн  
мэргэжилтэн

Т.Баяртуяа -Аж ахуйн нярав

3. Н.Золбоогын цалинг ТЗ-5-1 шатлалаар буюу 550744 /таван зуун тавин мянга долоон зуун дөчин дөрвөн/ төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.

4. Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн ам зүйн нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн бодлого хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Н.Золбоод үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР